



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СҮМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 12

Бор-Өндөр сум

ЧИГЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын газар ашиглалт, үйл ажиллагаанд холбогдох хууль журмын хүрээнд хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт цаг алдалгүй арилгуулж хийсэн ажлын тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар хуралдаанд танилцуулж ажиллах чиглэлийг сумын Засаг дарга Д.Отгонцэцэгт хүргүүлсүгэй.

2. Газрын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчин үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад хуулийн дагуу хугацаатай мэдэгдэл хүргүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох хүртэлх арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА



Э.МӨНХ-ЭРДЭНЭ